



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 421

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 6 нэрийн нийт 136,694,000.00 (нэг зуун гучин зургаан сая зургаан зуун ерэн дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (холбогдох зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001986
20-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 29 дугаар сарын 29-ны өдрийн
29 дугаар тогтоолын хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ, ХУДАЛДАХ ДООД ҮНЭ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
Жаргалант сэргээн засах төв 113 дугаар анги					
1	Альфард суудлын автомашин, улсын дугаар 69-02 УНС	2004/2016	1	7,500,000.00	4,000,000.00
хэсгийн дүн			1	7,500,000.00	4,000,000.00
Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар					
2	Уаз 469 /31512/ суудлын автомашин, улсын дугаар 33-88 ГАА	2013/2013	1	20,500,000.00	2,000,000.00
3	Газель тусгай зориулалт автомашин, улсын дугаар 69-02 ГАУ	2015/2015	1	68,925,000.00	3,500,000.00
4	Старекс ачааны автомашин, улсын дугаар 98-68 ГАУ	2007/2013	1	7,226,000.00	3,500,000.00
5	Ландкрузер- 80, улсын дугаар 01-05 ГАО	1997/2007	1	27,000,000.00	6,000,000.00
хэсгийн дүн			4	123,651,000.00	15,000,000.00
Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар					
6	Аврах ажиллагааны түргэн тусламжийн автомашин, улсын дугаар 46-05 ГСА	2004/2012	1	5,543,000.00	3,500,000.00
хэсгийн дүн			1	5,543,000.00	3,500,000.00
Нийт дүн			6	136,694,000.00	22,500,000.00
				(нэг зуун гучин зургаан сая зургаан зуун ерэн дөрвөн мянга)	(хорин хоёр сая таван зуу)